

Аудит хийгдэх нэгж:  
Төрийн захиргаа, удирдлагын газар

Огноо:  
2023.01.20

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

### **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

**Аудитын нэр: Шилэн данс**

**Жил: 2022 оны жилийн эцэс**

**Улаанбаатар хот**

**2023 он**

## **АГУУЛГА**

1. АУДИТЫН ЗОРИЛГО
2. ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ
3. ТАНИЛЦУУЛГА
4. АУДИТЫН ҮР ДҮН
5. ДҮГНЭЛТ
6. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

## **НЭГ. АУДИТЫН ЗОРИЛГО**

Байгууллагын төсөв, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, иргэд олон нийтэд мэдээллийг нээлттэй, үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээлсэн шилэн дансны мэдээллийн санг бүрдүүлэхэд аудитын зорилго оршино.

## **ХОЁР. ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ**

Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2022 оны төлөвлөгөөний биелэлт, “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд ХШҮДАГ-ын дотоод аудит хариуцсан мэргэжилтэн Л.Бадамханд дотоод аудит хийлээ.

“Шилэн дансны тухай”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг АМГТГ-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байна

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих төсөв гүйцэтгэлийн 9 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 төрлийн мэдээлэл, бусад 6 төрлийн мэдээллийг бүрэн мэдээлсэн ба хуулийн хугацааг хоцроосон 6 мэдээлэл байршуулсан.

2021 оны 12 дугаар сард хийсэн дотоод аудитаар хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил 11 гарч байсан бол 2022 оны байдлаар 6 болж буурсан нь дотоод аудитаар өгсөн зөвлөмж үр дүнтэй болсон үзүүлэлттэй байна.

Зөрчлийн тоо буурсан хэдий ч хуулийн хугацаанд мэдээлэх үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

## **ГУРАВ. ТАНИЛЦУУЛГА**

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийхдээ 2022 оны шилэн дансны цахим санд оруулсан мэдээлэл, агентлагийн даргын 2022 оны эхний хагас жилийн А-170 ширхэг, Б-158 ширхэг тушаалтай танилцаж, аудитыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2022 оны АМГТГ-ын данснуудын хуулгыг СХОХ-ээс гаргуулан авч шилэн дансны цахим санд оруулах мэдээллийг бүрэн гүйцэт цаг хугацаанд нь мэдээлсэн байдалд хяналт тавьж дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Агентлагийн даргын “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн А/18 тушааллаар батлагдсан төлөвлөгөөнд тус мэдээллийг байршуулан ажиллаж байсан мэргэжилтэнгүүд бүтцээр өөрчлөгдсөн тул шинээр томилогдсон ажилтан албан хаагчдад ажлын хэсгийн нарийн бичиг болон байгууллагын админы хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд заавар зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Комиссын бүрэлдэхүүн батлах тухай” тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүн байнгын давтамжтай үнэлгээний хороонд ажилладаг бөгөөд тус гишүүдийг сонгон шалгаруулалтын комисст ажиллахад тухай бүр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг үнэлгээний хорооны нарийн бичгээс авч шилэн дансны мэдээллийн санд оруулж ажлын хэсэг нягт уялдаа холбоотой, ажиллах талаар ХШҮДАГ-аас зөвлөмж хүргүүлсэн.

Шилэн дансны цахим санд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан хэдий ч засвар хийх, нэмж мэдээлэл байршуулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж программ өөрчлөгддөг байна.

## **ДӨРӨВ. АУДИТЫН ДҮН**

Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж, Шилэн дансны нэгдсэн цахим санд 20 төрлийн мэдээллийг 145 удаа хандалт хийж хуулийн хугацаанд 139 мэдээллийг байршуулсан ба 6 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тухай бүр мэдээллэхийг 8 сард СХОХ-ийн эдийн засагч С.Байгальмаа хугацаа хоцроож мэдээлсэн.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, тухай бүр байршуулах мэдээллийг 11 сард С.Байгальмаа хугацаа хоцроож мэдээлсэн.

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, тухай бүр тавих мэдээллийг 8, 9 сард тухайн үед хариуцан ажиллаж байсан Д.Дарьхүү хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, тухай бүр байршуулах мэдээллийг 4 сард тухайн үед хариуцан ажиллаж байсан Б.Алтан-Очир, 8 сард ТЗУГ-ын мэргэжилтэн Т.Болорцэцэг нар хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дах заалт /байгууллагын батлагдсан орон тоонд *орсон өөрчлөлт*/, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйл /*хүний нөөцийн ил тод байдал*/, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 3.2.17 дах заалтын дагуу хавсралт 23-аар мэдээлдэг. Тус мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулах үүрэгтэй ТЗУГ-ын мэргэжилтэн Т.Болорцэцэг 2022 оны зарим мэдээллийг ойлголтын буруугаас зөрүүтэй мэдээлсэн байсанд заавар, зөвлөмж хүргүүлж ажилласан.

- Сургалтын мэдээллийг 2023 онд 4 байсныг 9 гэж мэдээлсэн,
- Хүүхэд асрах чөлөөтэй ажилтан албан хаагчдын мэдээллийг 2021 оны мэдээллийг өөрчлөөгүй 8 гэж зөрүүтэй мэдээлсэн байна.
- Мөн тухайн мэдээллийн дараа сарын 8-ны дотор оруулах мэдээллийг тухайн сард оруулаагүй дараа сард нь оруулж мэдээлсэн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, мэдээллийн тухай бүр шилэн дансны санд байршуулж байсан ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Алтан-Очир 5 сард ажлаас чөлөөлөгдөж, ТЗУГ-ийн мэргэжилтэн

Т.Болорцэцэг 2022 оны 8 дугаар сарын 18-наас хавсран гүйцэтгэдэг ажил үүргийн дагуу гүйцэтгэсэн. Т.Болорцэцэг агентлагийн даргын 2022.6.15-ны өдрийн А/65 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүний мэдэгдлийг 10 сард нөхөж мэдээлсэн, 2022.7.7-ны өдрийн А/81 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүний мэдэгдлийн 11 сард нөхөж мэдээлсэн. 2022.7.7-ны өдрийн А/79 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2 гишүүн, тухайн өдрийн А/80 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүний мэдээллийг нөхөж оруулаагүй. 2022.10.14-ний өдрийн А/119 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 1 гишүүн, 2022.10.27-ны өдрийн А/131 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 5 гишүүн, 2022.12.28-ны өдрийн А/168 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны 1 гишүүний мэдээллийг дутуу мэдээлж **НИЙТ-14** мэдээллийг дутуу байршуулсан зөрчил илэрсэн.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (*тухай бүр*), нийт байршуулбал зохих мэдээллээс доорх хүснэгтэд байгаа **16** төрлийн **310,737,776** төгрөгийн мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

/хүснэгт-1/

| Дансны дугаар   | Дансны нэр | Огноо      | Харилцагч байгууллага                     | Зарлага               | Гүйлгээний утга                                                             |
|-----------------|------------|------------|-------------------------------------------|-----------------------|-----------------------------------------------------------------------------|
| 100900018010    | Төрийн сан | 2022-01-27 | 303933 - Ашигт Малтмал Газрын тосны Газар | 6,950,000.00          | Тушаал№Б/01 дагуу ахмадуудад хүндэтгэл үзүүлэх бэлнээр татав                |
| 100900018010    | Төрийн сан | 2022-03-04 | 303933 - Ашигт Малтмал Газрын тосны Газар | 5,760,000.00          | Тушаал№Б/17 дагуу баяр хүргэж                                               |
| 100900018010    | Төрийн сан | 2022-05-26 | 298333 - Голомт банк                      | 10,250,000.00         | Тушаал Б-48 жагсаалтаар хүүхдийн бэлэг                                      |
| 100900018010    | Төрийн сан | 2022-09-28 | 303933 - Ашигт Малтмал Газрын тосны Газар | 13,700,000.00         | Тушаал№Б/99 дагуу ахмад настанд хүндэтгэл үзүүлэх бэлнээр татав             |
| 100900018007    | Төрийн сан | 2022-11-09 | 304357 - ЗГБНУГазар                       | 30,000,000.00         | 5323533-АМГТГазар Байр ашиглалтын зардалд 11-р сар                          |
| 100900018007    | Төрийн сан | 2022-12-23 | 307609 - Софт Ментор ХХК                  | 7,237,515.71          | Гэрээ№2022/43 дагуу вирусн программын жилийн хураамж - Kaspersky            |
| 100900018010    | Төрийн сан | 2022-12-20 | 298333 - Голомт банк                      | 9,900,000.00          | Тушаал№Б/143 жагсаалтаар хүүхдийн бэлэг                                     |
| 100900018010    | Төрийн сан | 2022-12-23 | 262199 - Шимон ХХК                        | 19,835,000.00         | 5323533-АМГТГазар Гэрээ№2022/71 дагуу 2 давхрын оо өрөөний засварын зардалд |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-20 | 304700 - ББНТ ХХК                         | 7,546,000.00          | 5323533-АМГТГазар захиалгын дагуу албан хэрэгцээнд барааны үнэ              |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-20 | 262187 - Инженер Геодези                  | 9,525,000.00          | 5323533-АМГТГазар Захиалгын дагуу албан хэрэгцээнд                          |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-21 | 306731 - Рүүстэр монголия                 | 9,625,000.00          | 5323533-АМГТГазар гэрээний дагуу ажлын гуталны үнэ                          |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-22 | 307943 - Роял Үенч ХХК                    | 9,625,000.00          | 5323533-АМГТГазар гэрээний дагуу хөдөө ажлын                                |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-26 | 300435 - Киберком-ххк                     | 9,780,000.00          | 5323533-АМГТГазар захиалгын дагуу албан хэрэгцээнд тоног төхөөрөмж үнэ      |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-23 | 306902 - Техно зон ХХК                    | 15,990,000.00         | 5323533-АМГТГазар Гэрээ№002/002 дагуу тоног төхөөрөмжийн үнэ                |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-16 | 298831 - Сухайт хайрхан ХХК               | 37,080,000.00         | 5323533-АМГТГазар Гэрээний дагуу төлбөрийг шилжүүлэв                        |
| 100900018024    | Төрийн сан | 2022-12-20 | 299517 - Би Си Ти ХХК                     | 107,934,260.00        | 5323533-АМГТГазар Гэрээ№2022/70 дагуу тоног төхөөрөмжийн үнэ                |
| <b>НИЙТ ДҮН</b> |            |            |                                           | <b>310,737,775.71</b> |                                                                             |

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, (Тухай бүр) мэдээллийг 2022.1-10 сард байршуулж байсан ТЗУХ-ийн /хуучин нэрээр/ мэргэжилтэн Д.Дарьхүү, агентлагийн даргын А/40, А/109, А/125, А/126, А/131 дүгээр тушаалыг 2022.11-12 сард ТЗУГ-ын Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн Г.Байгальмаа, агентлагийн даргын А/146, А/156, А/166 дугаар тушаалыг, журмын 10 дугаар хавсралтад заасан маягт болон PDF форматаар шилэн дансны цэсэд байршуулаагүй зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Мөн Г.Байгальмаа нь дээрх мэдээлвэл зохих чиг үүрэгт хамааралгүй байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 11 төрлийн мэлээллийг шилэн дансны цахим санд байршуулсан байдалд заавар зөвлөмж өгсөн.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, (Тухай бүр) нийт мэдээлбэл зохих 1,790 нэр төрлийн, орлогын 320,568,843,647 төгрөг, зарлагын 328,296,744,898 төгрөгийн мэдээллийг СХОХ-ийн нягтлан бодогч Х.Чулуунцэцэг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж ажилласан.

## **ТАВ. ДҮГНЭЛТ**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан *“тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх”* гэсэн заалтанд нийцүүлж, агентлагийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг чиг үүргээ “сайн” үнэлгээтэй хэрэгжүүлсэн.

Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д *“Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна”* гэсэн заалтын дагуу цахим самбар байршуулж, нээлттэй ил тод мэдээллээр олон нийтийг чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажилласан байна.

Шилэн дансны цахим санд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан хэдий ч засвар хийх, өөрчлөлт оруулах, нэмж мэдээлэл байршуулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж программ өөрчлөгддөг. Энэ нь [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудас төгс боловсронгуй бус байгааг харуулж байна. Тухайлбал:

- Дараа жилийн төсвийн төсөл (*Бүтэн жилээр*)
- Байгууллагын батлагдсан төсөв (*Бүтэн жилээр*)
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (*Бүтэн жилээр*) зэрэг мэдээллүүдийг жил бүрийн 1 сарын 10-ны дотор цахим хуудсанд байршуулдаг бөгөөд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд мэдээллийг нэмэх, засварлах боломжгүй байдаг. Мэдээллийн өөрчлөлтийг оруулсан тохиолдолд хугацаа хоцроосон төлөвтэй болсноор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, үндэсний аудитын газар болон хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын шалгалтын үнэлгээнд сөргөөр нөлөөлдөг.

Шинэчлдэгсэн шилэн дансны системийг 2023 оны 1 сарны 1-нээс ашиглаж эхэлсэн бөгөөд байгууллагын админ буюу дотоод аудит хариуцсан мэргэжилтэн, шилэн дансанд



мэдээлэл байршуулдаг ажилтан албан хаагчид Сангийн яамнаас өгсөн заавар видео сургалт, видео хичээлд хамрагдаж мэдээллийн тухай бүр авч ажилласан.

#### **ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

1. Шилэн дансны мэдээлэл байршуулах эрх бүхий ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлж ажиллах. Мэдээллийг үнэн зөв, бодитой, хуулийн хугацаанд бүрэн гүйцэд шилэн дансны цахим хуудсанд байршуулж хэвших.
2. Заавар зөвлөмж авсан албан хаагчид зөвлөмжийг хэрэгжүүлж, мэдээллийг 2023 оны 1 дүгээр сард нөхөж оруулах талаар анхаарч ажиллах.
3. АМГТГ-ын газрын даргын 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн мэдээлэл солилцож, ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж, заавар, зөвлөмж авах.
4. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийг хуулийн хугацаа хоцроох мөн бүрэн гүйцэт бус мэдээлэх зөрчлүүд удаа дараа давдагдаж байгаа тул ажлын хариуцлагыг дээшлүүлж, үнэн зөв мэдээлэхэд анхаарч, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцож ажиллах.
5. Цаашид зөрчил гаргасан алдсан албан хаагчид хариуцлага тооцож ажилладаг байх.
6. Мэдээллийг нэмж оруулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж өөрчлөгдөх тул Сангийн яамны шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнаас асууж зөвлөгөө авах.
7. Шинэчилсэн системээр тухай бүр оруулах мэдээллийг хуулийн дагуу 7 хоногийн дотор оруулахыг анхаарч ажиллах. /Орлого, зарлагын гүйлгээ, тушаал шийдвэрүүд гэх мэт 7 хоногийн дотор оруулах мэдээллүүд хамарна/

Танилцсан: АМГТГ-ын дарга

Л.Баярмандал

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

П.Цэрэнлхам

Тайлан бичсэн:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн

Л.Бадамханд

Танилцсан:

ТЗУГ-ын дарга

Г.Мөнхсайхан

ТЗУГ-ын мэргэжилтэн

Т.Болорцэцэг

ТЗУГ-ын мэргэжилтэн

Г.Байгалмаа

СХОХ-ийн нягтлан бодогч

Х.Чулуунцэцэг

СХОХ-ийн эдийн засагч

С.Байгальмаа

Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар:.....

.....  
.....  
.....

2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

